



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН

*НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН*

# 2025





## Агуулга

01 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

02 АРИЛЖААЛАГДАЖ БУЙ ВИРТУАЛ ХӨРӨНГӨ, АРИЛЖААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

03 ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

04 САНХҮҮ ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

*ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ*

Хүснэгт 1. Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл

Хүснэгт 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл

Хүснэгт 3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл

Хүснэгт 4. Нийт орлогын тайлан

*ЗУРГИЙН ЖАГСААЛТ*

Зураг 1. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн тоо

Зураг 2. Дотоод виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн

Зураг 3. Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн

Зураг 4. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээл дэх бүртгэлийн төлөв

Зураг 5. Виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ

Зураг 6. Баталгаажуулалт хийсэн харилцагчийн төрөл

Зураг 7. Нийт харилцагчдын мэдээлэл

## Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн ерөнхий танилцуулга

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)–нд нэр бүхий 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч бүртгэлтэй байна.


Хүснэгт 1. Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Бүртгүүлсэн огноо	Арилжааны платформын хаяг	Үйл ажиллагааны чиглэлийн тоо
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	6210139	2017.08.01	2022.09.21	Trade.mn	5
2	“Койн Хаб” ХХК	6693326	2021.04.06	2022.09.21	Coinhub.mn	5
3	“Айдакс” ХХК	6803016	2021.12.30	2022.09.21	Idax.exchange	5
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	3645789	2021.09.23	2022.10.10	Ncx.mn	3
5	“Корекс” ХХК	6752586	2021.09.07	2022.10.10	Corex.mn	5
6	“Икс Мета” ХХК	6784771	2021.11.18	2022.10.10	X-meta.com	5
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	6719791	2021.06.20	2022.10.10	Complex.mn	5
8	“Чойжин Алтекс” ХХК	6785123	2021.11.18	2022.10.10	Altex.mn	5
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	6671845	2021.03.04	2022.10.10	Zoos.digital	5
10	“Капекс капитал” ХХК	6792987	2021.12.07	2022.11.25	Capex.mn	3
11	“Анд дэнөүд” ХХК	6783147	2021.11.12	2022.11.25	Denode.io	5
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	6906834	2022.08.25	2023.01.13	Octagon.mn	5

Дээрх 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс 11 нь Улаанбаатар хотод байршилтай бол “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд байршилтай байна. Түүнчлэн 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээс 10 нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1–т заасан 5 үйлчилгээг үзүүлэхээр, “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК болон “Капекс капитал” ХХК нь виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих, виртуал хөрөнгийг шилжүүлэх, виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах гэсэн 3 үйлчилгээг үзүүлэхээр бүртгэл хийлгэсэн.

## ВХҮҮ дээр арилжаалагдаж буй дотоод болон гадаад виртуал хөрөнгийн тоо


Зураг 1. Арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн тоо




2025 оны нэгдүгээр улирлын байдлаар бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан нийт 440 виртуал хөрөнгө арилжаалагдаж байгаа бөгөөд үүнээс 37 дотоодын виртуал хөрөнгө, 403 гадаадын виртуал хөрөнгө байна. Нийт арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн 91.6%-ийг гадаадын виртуал хөрөнгө эзэлж байна.

## ВХҮҮ-ийн арилжааны зохион байгуулалт

Зураг 2. Дотоод виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн (тэрбум төгрөг)



Зураг 3. Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн (тэрбум төгрөг)




Хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар гадаадын виртуал хөрөнгийн 401.2 тэрбум төгрөгийн, дотоодын виртуал хөрөнгийн 16.04 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдэж, нийт арилжааны дүн өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өссөн байна. Мөн “Чойжин Алтекс” ХХК, “Анд Дэнөүд” ХХК дээр дотоодын виртуал хөрөнгө, “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК дээр гадаад, дотоод виртуал хөрөнгийн арилжаа тус оны нэгдүгээр улиралд хийгдээгүй болно.

## ВХҮҮ дээр арилжаалагдаж буй дотоодын виртуал хөрөнгө


Зураг 4. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээл дэх бүртгэлийн төлөв

Дотоодын виртуал хөрөнгөөс “INC, ARDX” нь хамгийн олон буюу 5 ВХҮҮ дээр, “ZESC” 4 ВХҮҮ дээр, “SPC, ADMC” нь 3 ВХҮҮ дээр, “OBOT, MONT, WPL, MNFT” нь 2 ВХҮҮ дээр үлдсэн нь зөвхөн 1 ВХҮҮ дээр тус тус арилжаалагдаж байна.



Зураг 5. Виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ (тэрбум төгрөг)

■ 2024 оны нэгдүгээр улирал  
■ 2025 оны нэгдүгээр улирал



Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчид дээр 2025 оны нэгдүгээр улиралд хийгдсэн нийт арилжаа дүн өмнөх оны мөн үеэс 3.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



Нийт гадаад виртуал хөрөнгийн арилжааны 74.3 хувийг USDT, XRP, ETH, BTC, DOGE, SOL болон PEPE, харин дотоодын арилжааны 94.3 хувийг ARDX, SPC, IHC гэх койн, токенүүд тус тус бүрдүүлж байна.



## Хүснэгт 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл

№	Виртуал хөрөнгийн нэр	Анхны ханш	Бүх цаг үеийн хамгийн	Бүх цаг үеийн хамгийн дээд ханш	2025.03.31-ний байдлаарх ханш	2025.01.01–03.31 хүртэл нийт арилжааны хэмжээ (төгрөгөөр)	Зах зээлийн үнэлгээ
1	ADMC	1	0.01	1.49	0.1	255,365.13	1,613,296,422.27
2	ARDX	1	0.79	445.00	29	8,687,163,880.51	15,794,106,520.96
3	ARDT	4600	2000.01	5199.00	2445.00	28,084,798.85	8,572,911,601.24
4	BES	0.14	0.02	199.92	0.02	0.00	699,826.50
5	BID	0.4	0.0001	0.79	0.11	1,114,187.77	1,024,497,235.01
6	CHB	30	3.2	248.8	7.66	213,245,361.92	11,004,222,337.03
7	IHC	0.30	0.06	6.34	0.08	2,084,465,464.06	52,711,278,073.73
8	SPC	0.2	0.087	3.00	0.36	4,358,625,391.84	17,630,084,680.22
9	MNFT	0.3	0.0106	49.5	0.04	163,033,969.10	3,985,623,628.61
10	MNDT	1.00	1.00	1.00	1.00	0.00	1,649,142.44
11	EAC	0.01	0.001	0.007	0.001	254,073.32	341,452,240.94
12	DAC	0.33	0.003	0.513	0.005	2,319,127.66	18,463,945.91
13	WPL	1	0.006	1.4297	0.11	1,845,015.22	432,966,383.53
14	ELFC	0.3	0.003	0.3	0.005	1,089,764.19	431,636,390.39
15	ICTG	130	0.01	180.00	20.00	1,910,600.53	3,425,594,037.30
16	DC	1.20	0.14	4.00	0.12	141,347.10	89,185,617.24
17	ZESC	1.00	0.0532	107.9	0.27	22,830,010.26	135,896,050.45
18	OBOT	114	5.053	285.00	28.08	190,407,443.49	631,422,271.47
19	MONT	1.00	1.00	1.00	1.00	53,756,733.27	257,705,244.72
20	TRD	1.00	0.001	55.00	0.17	41,440,516.93	3,800,000,000.00
21	NTC	0.5	0.04	1.00	0.4	10,931,835.04	5,368,878,390.40
22	CRX	15	0.29	30.1	0.6	4,322,741.99	132,518,853.70
23	ZOOS	1.00	0.55	0.55	-	0.00	133,446,223.6

24	CPX	0.25	0.0004	0.5004	0.006	135,353.63	57,962,821.88
25	GER	0.1	0.0001	0.1	0.03	0.00	126,459,073.64
26	CARE	0.15	0.0001	0.15	0.003	7,109.69	7,187,725.56
27	CAEL	2.85	0.013	3.99	0.08	0.00	79,349,529.85
28	BDC	70	0.0492	127.95	19.9	0.00	3,360,297.97
29	CAMEL	0.2	0.0012	0.9996	0.04	0.00	16,811,774,065.3
30	MSC	0.25	0.0011	0.35	0.22	197,601.02	605,408,940.74
31	MOZO	0.3	0.0004	0.539	0.05	59,229.54	304,310,478.08
32	MGLC	0.89	0.011	4.99	0.01	0.00	70,129,135.01
33	IIT	3.00	0.013	3.99	0.01	1,055.00	1,952,593.57
34	URGX	1	0.0001	3.00	0.12	23,104,383.01	395,682,350.76
35	DAXT	1ARDT= 1ARDX	16.00	55.68	21.76	4,055,926.58	26,432,756.15
36	ARDM	0.039	0.005	0.18	0.01	65,010,219.05	1,088,701,761.15
37	BS9	1000	880.00	2000.00	1200.00	2,312,107,408.38	57,750,857,598.91

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр арилжаалагдаж буй дотоодын 37 виртуал хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 167.02 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс 1.01 хувиар буурсан байна. (Зах зээлийн үнэлгээг тооцохдоо жигнэсэн дундаж ханшаар тооцоолсон болно.)

Мөн тус улиралд нийт арилжааны 94.3 хувийг эзэлж буй (ARDX, SPC, IHC) гэх дотоодын 3 виртуал хөрөнгө дээр өдөрт дунджаар 168.1 сая төгрөг, үлдсэн 5.6 хувийг бүрдүүлж буй дотоодын 34 виртуал хөрөнгө дээр өдөрт дунджаар 10.1 сая төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.

## Харилцагчийн мэдээлэл

2025 оны нэгдүгээр улирлын байдлаар бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр давхардсан тоогоор нийт 941,180 харилцагч бүртгэлтэй бөгөөд өмнөх оны мөн үеэс 7.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


Хүснэгт 3. Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Бүртгэлтэй харилцагч	Баггалгаажуулалт хийсэн харилуагч	Идэвхитэй арилжаа хийдэг харилцагч
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	224,476	86,371	3,124
2	“Койн Хаб” ХХК	205,071	121,478	4,211
3	“Айдакс” ХХК	197,715	134,718	3,100
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	13,882	4,977	7
5	“Корэкс” ХХК	65,582	30,546	8
6	“Икс Мета” ХХК	22,370	11,966	1,060
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	128,957	53,827	121
8	“Чойжин Алтекс” ХХК	1,170	532	74
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	2,228	1,183	0
10	“Капекс капитал” ХХК	32,905	16,077	26
11	“Анд дэнөүд” ХХК	3,535	709	13
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	43,289	2,555	4
Нийт		941,180	464,939	11,748


Зураг 6. Баталгаажуулалт хийсэн харилцагчийг төрлөөр ангилбал:



Насны бүлгээр




Хүйсээр



Нийт баталгаажуулалт хийсэн харилцагчийн 85 хувийг 16–45 насны харилцагчид эзэлж байна.

Зураг 7. Нийт харилцагчдын мэдээлэл



Нийт бүртгэлтэй харилцагчаас 49.4 хувь нь баталгаажуулалт хийсэн, 1.2 хувь нь идэвхтэй арилжаа хийдэг харилцагч байна.

## ВХҮҮ–ийн санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 2025 оны нэгдүгээр улирлын байдлаар санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтээр нийт хөрөнгийн дүн 76.02 тэрбум төгрөг, эргэлтийн хөрөнгө 58.2 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 17.8 тэрбум төгрөг байна. Нийт хөрөнгийн дүн өмнөх оны мөн үеэс 31.2 хувиар, эргэлтийн хөрөнгө 53.5 хувиар тус тус өсөж, харин эргэлтийн бус хөрөнгө 11.2 хувир буурсан үзүүлэлттэй байна.

Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн 76.02 тэрбум төгрөг, өр төлбөрийн дүн 54.5 тэрбум төгрөг, эздийн өмчийн дүн 21.5 тэрбум төгрөг байна. Тайлант улиралд нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн өмнөх оны мөн үеэс 31.2 хувиар, өр төлбөр 61.2 хувиар тус тус өсөж, харин эздийн өмч 10.8 хувир буурсан үзүүлэлттэй байна.

2024.03.31  
2025.03.31

## НИЙТ ХӨРӨНГӨ (ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР)



## ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ (ТЭРБУМ ТӨГРӨГӨӨР)



## Хүснэгт 4. Нийт орлогын тайлан (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024.03.31	2025.03.31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,265,752,167.58	1,663,946,670.42
2	Борлуулалтын өртөг	321,493,323.42	333,453,846.71
3	Тайлан үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,042,368,874.06	(2,065,529,917.04)
4	Нийт орлогын дүн	5,601,250,251.97	2,264,544,846.47
5	Нийт зарлагын дүн	2,558,881,377.89	4,330,074,763.51

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 2025 оны нэгдүгээр улирлын орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад нийт орлогын дүн 2.3 тэрбум төгрөг, нийт зардал 4.3 тэрбум төгрөг байна. Мөн тус онд 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь нийт 2.1 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

## ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН ХЭЛТЭС



Засгийн газрын 4 байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-261674



[www.frc.mn](http://www.frc.mn)



[vaspd@frc.mn](mailto:vaspd@frc.mn)



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia